



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 381

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх эсэсэг, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай:

1.1 Болдын Цэнгэл нь өөр ажил, албан тушаалд шилжин ажиллах болсонтой холбогдуулан, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 01/4956 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг харгалзан “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын албан тушаалаас 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлж, түүнтэй байгуулсан контрактыг холбогдох хууль тогтоомжийн дагуу дуусгавар болгох;

1.2 Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 01/4955 дугаар албан бичгээр ирүүлсэн санал, Авлигатай тэмцэх газрын 2019 оны 05/7631 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус харгалзан Рэнцэнхандын Батсүхийг “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлаар томилж, контрактыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж ажиллах.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
TYP ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
TYP ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЭРДЭНЭБАЯР